



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/113

Хархорин сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн “Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 15 тоотод байрлалтай 1,5 га (15000м²) газрыг боловсролын байгууллагын зориулалтаар (8301395)-д Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын Номын хүрдэн сургуульд 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг захирал (П.Эрдэнэбаатар)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын Номын хүрдэн сургуульд гэрээ байгуулан, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

491100225